

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/182/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Албан шаардлага	17
5.2 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН
ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Д.ЗАГДГОЧОО ТАНАА**

Судс. акт. 28 № ОАА-Судс/182/НА-СТА-ТМД
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын дагуу тайлант оны 4 сараас эхлэн орон нутгийн нэмэгдэл олгосон болон 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос шалтгаалан тус газрын 2024 оны цалин хөлс нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын зардал нэмэгдэж, нийт урсгал зардлын 68.3 хувийг эзэлж байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд нийт түлш халаалтын зардалд 92,628.5 мянган төгрөгийн үнэ бүхий 633.4 тонн нүүрс зарцуулсан ч норм, нормативыг тогтоогоогүйгээс 1-р сард 76.8 тонн, 2-р сард 64.8 тонн, 10-р сард 84.0 тонн, 11-р сард 106.4 тонн, 12-р сард 163 тонн гэх мэтчилэн харилцан адилгүй нүүрс зарцуулсан байгаа нь нүүрсний зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул байгааг харуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолоор тайлант оноос эхлэн Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Шаамар сум дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийг нэгтгэж, Политехник коллеж болгон зохион байгуулж, үйл ажиллагаа явуулсан.

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллежийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хүрээнд 97 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	565,185,676.93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	105,564,379.36
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	0.00	105,564,379.36
31210	Төгрөг	0.00	105,564,379.36
31211	Төрийн сангийн харилцах	0.00	105,564,379.36
33	АВЛАГА	0.00	13,140,000.00
33500	Бусад авлага	0.00	13,140,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	13,140,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	446,481,297.57
35100	Түүхий эд материал	0.00	134,591,526.47
35110	Тусгай зориулалттай материал	0.00	134,131,826.47
35130	Эм боох материал	0.00	459,700.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0.00	883,180.00
35400	Хангамжийн материал	0.00	303,746,591.10
35410	Бичиг хэргийн материал	0.00	14,540,000.00
35420	Аж ахуйн материал	0.00	58,469,803.50
35440	Түлш, шатах тослох материал	0.00	6,031,754.50
35450	Барилгын засварын материал	0.00	23,846,214.78
35460	Хүнсний материал	0.00	4,209,240.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	196,649,578.32
35500	Биологийн хөрөнгө	0.00	5,000,000.00
35600	Мал амьтад	0.00	2,260,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	6,036,022,458.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	6,036,022,458.64
39200	Биет хөрөнгө	0.00	5,123,179,958.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.00	6,097,000,525.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-1,731,615,745.67
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	198,851,918.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-179,590,737.96
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0.00	1,262,084,189.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-844,109,751.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	305,841,494.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-136,830,012.56
39209	Зам, гүүрний байгууламж	0.00	40,696,967.89
39210	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-14,678,824.16
39217	Ном	0.00	125,529,934.04
39300	Биет бус хөрөнгө	0.00	912,842,500.00
39301	Программ хангамж	0.00	22,593,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-21,700,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	911,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	6,601,208,135.57
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	668,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	668,500.00
41300	Өглөг	0.00	668,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	668,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	6,600,539,635.57
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	6,600,539,635.57
51200	Хуримтлагдсан үр дүн	0.00	6,600,539,635.57
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	41,046.00

51220	Тайлант үеийн үр дүн	0.00	6,600,498,589.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	6,601,208,135.57

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	10,830,350,688.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	6,847,374,219.41
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	6,847,374,219.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	26,617,617.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	24,132,617.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	2,485,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	6,417,683,495.84
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	403,073,106.57
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	3,982,976,469.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	3,236,219,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	3,236,219,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	746,757,169.33
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	746,757,169.33
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	4,220,937,099.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	4,220,937,099.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	3,912,260,816.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	2,148,152,610.62
210101	Үндсэн цалин	0.00	1,198,306,092.82
210102	Нэмэгдэл	0.00	677,568,152.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	165,868,679.27
210104	Урамшуулал	0.00	106,409,685.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	269,105,360.10
210201	Тэтгэврийн даатгал	0.00	184,093,300.63
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	21,336,682.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	11,962,542.47
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	10,341,767.07
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	41,371,067.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	588,850,669.33
210301	Гэрэл, цахилгаан	0.00	52,814,417.13
210302	Түлш, халаалт	0.00	517,780,652.20
210303	Цэвэр, бохир ус	0.00	18,255,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	39,694,751.92
210401	Бичиг хэрэг	0.00	2,672,650.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	20,047,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	7,745,041.92
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	7,652,060.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	1,577,200.00
2105	Нормативт зардал	0.00	85,080,130.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	747,100.00
210502	Хоол, хүнс	0.00	84,333,030.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	141,240,030.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	65,500.00

210604	Урсгал засвар	0.00	141,174,530.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	25,461,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	25,461,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	614,676,264.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	20,379,065.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	47,036,062.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	547,261,137.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	308,676,283.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	308,676,283.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	184,940,283.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	111,392,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	12,344,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0.00	6,609,413,589.57
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	8,915,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.00	7,275,000.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0.00	1,640,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	0.00	6,600,498,589.57

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	4,009,594,086.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	26,617,617.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	26,617,617.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	26,617,617.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	26,617,617.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	3,982,976,469.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	3,236,219,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	3,236,219,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	746,757,169.33
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	746,757,169.33
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	3,731,154,606.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	3,731,154,606.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	3,422,478,323.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	2,147,484,110.61
210101	Үндсэн цалин	0.00	1,197,637,592.82
210102	Нэмэгдэл	0.00	677,568,152.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	165,868,679.27
210104	Урамшуулал	0.00	106,409,685.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	269,064,314.11
210201	Тэтгэврийн даатгал	0.00	184,052,254.63
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	21,336,682.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	11,962,542.47
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	10,341,767.08
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	41,371,067.78

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	586,556,069.33
210301	Гэрэл, цахилгаан	0.00	52,814,417.13
210302	Түлш, халаалт	0.00	515,486,052.20
210303	Цэвэр, бохир ус	0.00	18,255,600.00
2105	Нормативт зардал	0.00	92,708,000.00
210502	Хоол, хүнс	0.00	92,708,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	138,276,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	14,047,700.00
210604	Урсгал засвар	0.00	124,229,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	188,389,129.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	113,225,382.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	75,163,747.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	308,676,283.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	308,676,283.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	184,940,283.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	111,392,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	12,344,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	278,439,479.36
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	172,875,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	172,875,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	172,875,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	172,875,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-172,875,100.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	105,564,379.36
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	105,564,379.36

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	41,046.00	41,046.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	41,046.00	41,046.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,600,498,589.57	6,600,498,589.57
20	2024 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	0.00	0.00	6,600,539,635.57	6,600,539,635.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
-----	----------	------------	-----------------------------	------------------------------------	------

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,259,138,000.00	3,157,272,537.64	-101,865,462.36	96.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,259,138,000.00	3,157,272,537.64	-101,865,462.36	96.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,950,393,100.00	2,848,596,254.64	-101,796,845.36	96.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,205,612,400.00	2,147,484,110.61	-58,128,289.39	97.36
210101	Үндсэн цалин	1,106,771,400.00	1,197,637,592.82	90,866,192.82	108.21
210102	Нэмэгдэл	924,268,600.00	677,568,152.63	-246,700,447.37	73.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	174,572,400.00	165,868,679.27	-8,703,720.73	95.01
210104	Урамшуулал	0.00	106,409,685.89	106,409,685.89	#DIV/0!
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	275,701,600.00	269,064,314.11	-6,637,285.89	97.59
210201	Тэтгэврийн даатгал	187,477,100.00	184,052,254.63	-3,424,845.37	98.17
210202	Тэтгэмжийн даатгал	22,056,100.00	21,336,682.15	-719,417.85	96.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,028,100.00	11,962,542.47	934,442.47	108.47
210204	Ажилгүйдлийн даатгал	11,028,100.00	10,341,767.08	-686,332.92	93.78
210205	Эрүүл мэндийн даатгал	44,112,200.00	41,371,067.78	-2,741,132.22	93.79
2105	Нормативт зардал	92,708,000.00	92,708,000.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	92,708,000.00	92,708,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,494,900.00	28,122,400.00	-7,372,500.00	79.23
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	0.00	0.00	#DIV/0!
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,420,200.00	14,047,700.00	-7,372,500.00	65.58
210604	Урсгал засвар	14,074,700.00	14,074,700.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	340,876,200.00	311,217,429.92	-29,658,770.08	91.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	156,662,400.00	143,513,629.92	-13,148,770.08	91.61
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	184,213,800.00	167,703,800.00	-16,510,000.00	91.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	308,744,900.00	308,676,283.00	-68,617.00	99.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	308,744,900.00	308,676,283.00	-68,617.00	99.98
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	185,008,900.00	184,940,283.00	-68,617.00	99.96
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	111,392,000.00	111,392,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,344,000.00	12,344,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,259,138,000.00	3,262,836,917.00	3,698,917.00	100.11
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,259,138,000.00	3,236,219,300.00	-22,918,700.00	99.30
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,245,063,300.00	3,236,219,300.00	-8,844,000.00	99.73
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,074,700.00	26,617,617.00	12,542,917.00	189.12
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,074,700.00	26,617,617.00	12,542,917.00	189.12
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	105,564,379.36	105,564,379.36	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	0.00	68.00	0.00	
620001	Удирдах ажилтан	0.00	3.00	0.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	0.00	21.00	0.00	
620003	Үйлчлэх ажилтан	0.00	44.00	0.00	
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	370.00	361.00	0.00	97.57
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	370.00	361.00	0.00	97.57
632001	Төрийн өмчит МСҮТ	370.00	361.00	0.00	97.57
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.00	68.00	0.00	
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	0.00	31.00	0.00	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	0.00	37.00	0.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллеж *Ицаашид Политехникийн коллеж гэх/ нь “Ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хариуцлагатай, зөв хандлага, ур чадвартай мэргэжилтэй ажилтныг бэлтгэх”* гэсэн зорилго тавин ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон хэрэгжүүлж, ажилласан байна. Үүнд:

- *Мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах,*
- *Хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах,*
- *Үйлдвэрлэл дээр мэргэжлийн сургалт зохион байгуулах.*

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дугаар сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлт тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17-нд нэмэлт өөрчлөлт орсон,*

- *Боловсролын ерөнхий хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Политехник коллежийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Политехникийн коллеж нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тус байгууллагын үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан *Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 352,486.1 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	105,564.4	105,564.4
Авлага	0.0	13,140.0	13,140.0
Бараа материал	0.0	446,481.3	446,481.3
Үндсэн хөрөнгө	0.0	6,036,022.4	6,036,022.4
Нийт хөрөнгө	0.0	6,601,208.1	6,601,208.1
Өр төлбөр	0.0	668.5	668.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	0.0	6,600,539.6	6,600,539.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	0.0	6,601,208.1	6,601,208.1

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 105,564.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь үндсэн дансны зардлын хэмнэлтээс шалтгаалсан байна.

Авлага данс 13,140.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь харилцагч байгууллагаас нийлүүлэх хөрөнгө дутуугаас шалтгаалсан байна.

Бараа материалын данс 446,481.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагдсан нь бүтцийн өөрчлөлтөөр 402,863.1 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авснаас голлон шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс 6,043,297.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь бүтцийн өөрчлөлтөөр 8,777,047.9 мянган төгрөгийн хөрөнгө, 2,381,264.4 мянган төгрөгийн элэгдэл шилжүүлж авснаас голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийг нийт **2,767,469.8** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 1,063,008.4 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 132,876.0 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 725,647.7 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 92,708.0 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 44,945.8 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 321,127.4 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 132,876.0 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 254,280.5 мянган төгрөгөөр.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 1,242,315.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,142,604.0 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 142,825.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна/ төсвийн тодотгол, зохицуулалт хийж нийт **4,009,785.7** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 3,245,063.3 мянган төгрөг,
- Орон нутгийн төсвөөс 750,647.7 мянган төгрөг,
- Үндсэн үйл ажиллагааны орлогоос 14,074.7 мянган төгрөг.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,245,063.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 14,074.7 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,236,219.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 17,773.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 8,844.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **3,157,272.5** мянган төгрөг буюу **96.9** хувьтай тайлагнагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	308,744.9	308,676.3	68.6	100.0
2	Дотуур байрны үйлчилгээ	92,708.0	92,708.0	0.0	100.0
3	Боловсролын стандарт, сургалтын үйлчилгээ	2,719,078.3	2,630,430.2	88,648.1	96.7
4	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	124,532.1	111,383.3	13,148.8	89.4
5	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	14,074.7	14,074.7	0.0	100.0
	Дүн	3,259,138.0	3,157,272.5	101,865.5	96.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам /Тендер шалгаруулалтын арга/
1	Дотуур байрны хоол, хүнс худалдан авах	92,700.0	92,700.0	НТШ
2	Нүүр худалдан авах	115,500.0	32,200.0	Харьцуулалтын арга
3	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	157,753.9	157,753.9	НТШ
	Нийт дүн	285,873.9	285,873.9	

Дотуур байрны хоол, хүнс худалдан авах тендерийн 4 багцад Номунсэлэнгэ ХХК, нүүрс худалдан авах тендерийг 2 удаа зохион байгуулж, 11 сард Экопартнерс ХХК шалгарч тус тус гэрээ байгуулан, худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна.

Хичээл үйлдвэрийн дадлагын зардлын тендер нь амжилтгүй болсон тул өмнөх онуудад гэрээний үндсэн дээр бэлтгэн нийлүүлэлт хийж байсан Цахим Ертөнц ХХК, Сэлэнгэхан хүү ХХК, Сэлэнгэтитан ХХК, Алтан-Есүй ХХК зэрэг байгууллагуудтай гэрээ байгуулан, худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн цалингийн суутгалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт

хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,159,553.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **31,595.5** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагатай гэж дүгнэсэн.

Тайлант онд бүтцийн өөрчлөлт хийгдэж Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Шаамар сум дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийг нэгтгэж, Политехник коллеж болгон зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө болох 6,601,208.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон **66,012.1** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нэгдсэн эмнэлэг нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Байгууллагад бүртгэлтэй автомашинуудыг цэнхэр дугаартай болгосон,*
- *Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*
- *Гар утасны зардал гаргаагүй,*
- *Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт


Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Политехник коллеж нь мэдээлбэл зохих 29 төрлийн 183 мэдээллээс 165 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

Хугацаа хоцроосон:

- *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалтыг 1 удаа,*
- *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангиллыг 1 удаа,*

- Байгууллагын батлагдсан төсвийг 1 удаа,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 1 удаа,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг 1 удаа,
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг 2 удаа,
- Худалдан авах ажиллагааны тайланг 1 удаа,
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг 2 удаа,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг 2 удаа,
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 2 удаа,
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг 2 удаа,
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг 2 удаа.



Шийдвэрлэлт: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тайлант оноос эхлэн Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Шаамар сум дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийг нэгтгэж, Политехник коллеж болгон зохион байгуулж, үйл ажиллагаа явуулсан тул өмнөх онд санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус газрын төсвийн шууд захирагчийн бус **дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн** дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1.Өмнөх оны ажлыг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 50.0 хүртэл хувиар тооцож, үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал БШУЯ-ны 2024 оны 06 дугаар

сарын 24-ний өдрийн 2/2772 дугаар албан бичгээр 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өөрчлөлтгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр нягтлан бодогч Л.Баасанжав, Т.Түвшинжаргал нарт 2 сарын үндсэн цалин, нярав Э.Азжаргалд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт **5,234.0** мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар **53,620.9** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 2,000.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, 51,620.0 мянган төгрөгийн албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Албан хаагчдыг Улаанбаатар хот, аймаг, сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийн **1,323.9** мянган төгрөгийг давхардуулан тооцож, олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2.Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас нягтлан бодогч Т.Түвшинжаргалд олгосон **677.0** мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1.Орон нутгаас олгосон урсгал засварын зардлын санхүүжилтээс хөрөнгө худалдан авсан болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлсийг цалингийн төсвөөс

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

олгосон зэрэг нийт **51,620.0** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, хөрөнгийг бүрэн хүлээж аваагүйгээс 13,140.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Урсгал засварын зардлаас тавилга, эд хогшил худалдан авахад 50,220.0 мянган төгрөг зарцуулж 13,140.0 мянган төгрөгийн хөрөнгийг дутуу хүлээж авч, авлага үүсгэсэн,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас санхүүжүүлэх урсгал засвар хийлгэсний 1,400.0 мянган төгрөгийн ажлын хөлсийг цалингийн зардлаас олгосон гэх мэт.

Шийдвэрлэлт: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Нийт албан хаагчдын цалингаас дотуур байрны түрээс, хамтын сан зэрэг суутгалууд хийж байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх “Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно:” 119.1.4 “Хууль тогтоомжид заасан бусад тохиолдол” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Ажилчдын цалингаас зөвхөн хуульд заасан суутгалыг хийж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш **30** хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл



Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Хоолны хөнгөлөлт давхардуулан олгосон	1	1,323.9	1	1,323.9									
Цалингийн урьдчилгааг суутгаагүй	1	677.0	1	677.0									
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	51,620.0			1	51,620.0							
Цалингаас суутгал хийсэн	1						1						
Дүн	4	53,620.9	2	2,000.9	1	51,620.0	1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны цахим хуудсанд 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1							1	
	1							1	